



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

11 сарын 03 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

Анагаах ухааны салбарт оношлогоо,
эмчилгээний шинэ аргыг бүртгэх,
баталгаажуулах, мэдээлэх журам
батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 37.1 дэх заалтыг хэрэгжүүлэх
тушаал нь:

1. "Анагаах ухааны салбарт оношлогоо, эмчилгээний шинэ аргыг бүртгэх,
баталгаажуулах, мэдээлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Эрүүл мэндийн сайдын 2009
оны 452 тоот тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд
тооцсугай.

САЙД

С.ЛАМБАА

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 11
дүгээр сарын 03-ны өдрийн 353 тоот
тушаалын хавсралт

УХААНЫ САЛБАРТ ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ШИНЭ АРГЫГ БҮРТГЭХ, БАТАЛГААЖУУЛАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 37.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилготой бичиг юм.

Энэхүү журмын зорилго нь анагаах ухааны салбарт ажиллагсдын гаргасан шинэ санаачлагыг дэмжих, урамшуулах, тэдний шинээр санаачлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн оношлогоо, эмчилгээ, мэс заслын шинэ аргад хамаарах оюуны бүтээлийн мэдүүлгийг хүлээн авах, батлах, бүртгэх, гэрчилгээ олгох, мэдээний сан бүрдүүлэх, ашиглах, уламжуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Шинэ аргыг бүртгэж, баталгаажуулж, гэрчилгээ олгох нь бүтээлч үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, эмч, мэргэжилтэн, судлаачдын идэвхи санаачлагыг өрнүүлж, хүний өвчин шаналгааг илааршуулах, амь насыг хамгаах чиглэлээр эрүүл мэндийн салбарт инноваци, шинэчлэл, дэвшил амьдралд дэмжлэг үзүүлнэ.

Анагаах ухааны салбарт гаргасан оношлогоо, эмчилгээ, мэс заслын шинэ арга гэдэг нь тус улсад анх удаа бүтээсэн, уламжлалт аргуудаас давуу шинж чанартай оюуны бүтээлийг хэлнэ.

Энэхүү арга нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:

Шинэ аргын түвшин агуулсан (Эмчилгээ, оношлогооны тухайн аргын хувьд шинэ аргуудаас давуу шинж чанартай байвал түүнийг шинэ аргын түвшин агуулсан гэж үзнэ. Эмчилгээ, оношлогооны тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон аргыг цоо шинэ гэж үзнэ).

2. Практикт ашиглах боломжтой (оношлогоо, эмчилгээнд хэрэглэж болохыг биоанагаахын болон эмнэлзүйн туршилтаар баталсан аргыг практикт ашиглаж болох арга гэж үзнэ),

3. Хамрах хүрээ буюу анагаах ухаан, эрүүл мэндийн салбарт ашиглаж болох байдал,

4. Урьд өмнө ашиглаж байсан ижил төрлийн аргаас ялгагдах онцлогууд

Шинэ аргыг анагаах ухааны (Эрүүл мэндийн) болон бусад холбогдох салбарт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өөр мэргэжлийн хэн ч бүтээсэн байж болно.

Хоёр. Шинэ аргын мэдүүлгийг хүлээн авах

Шинэ аргын зохиогч (зохиогчид) өөрийн бүтээсэн шинэ аргаа бүртгүүлэх мэдүүлгээ харъяалах байгууллагын захиргаанд өргөн барина.

1. Бүрдүүлэх материал:

1.1. Мэдүүлэг (Маягтын дагуу)

1.2. Өөрийн анкет (Маягтын дагуу)

1.3. Бүтээлийн тодорхойлолт, танилцуулга,

1.4. Тухайн бүтээлийг хэрэглэж үр дүнг тооцсон байгууллагын даргын гарын үсэг зурж баталгаажуулсан дүгнэлт, тайлан,

1.5. Бүтээлийг хэлэлцүүлж шинэ болохыг тодорхойлсон эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, тогтоол

1.6. Гарын үсэг зурж баталгаажуулсан биоанагаахын болон эмнэлзүйн судалгаа, туршилтын үр дүн, тайлан,

1.7. Хүний бие, эрүүл мэндэд хохирол учруулахгүйг баталсан Мэргэжлийн салбар зөвлөлийн магадлагаа

Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан тухай холбогдох (хүрээлэн, төв) байгууллагын тодорхойлолт, дүгнэлт

Бүтээлийн талаар холбогдох байгууллага, хүмүүсээс ирүүлсэн санал, дүгнэлт

Байгууллагын бичиг хэргийн эрхлэгч өргөдлийн бүртгэлд бүртгэж авна.

Гурав. Шинэ аргын мэдүүлгийг хэлэлцэх

Шинэ аргын мэдүүлгийг холбогдох эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, дүгнэлт гаргана.

Зохиогч эрдэм шинжилгээний хүрээлэн төв, их сургуулиас өөр байгууллагад ажилладаг бол түүний бүтээлийг хэлэлцэх мэргэжлийн чиглэл бүхий эрдмийн зөвлөлд хандана.

Мэдүүлгийг хэлэлцүүлэхийн өмнө мэргэжлийн чиглэлээр 3 шинжээч томилон дүгнэлт гаргуулна.

Эрдмийн зөвлөл нь нууц санал хураалтаар шийдвэр гаргаж, тогтоолоор баталгаажуулна.

Дөрөв. Шинэ аргыг баталгаажуулах

Холбогдох материал, танилцуулга, эрдмийн зөвлөлийн шийдвэрийг ЭМЯ-ны ШУТЗ-ийн хуралдаанд танилцуулж, гишүүдийн гуравны хоёрын саналаар шинэ бүтээл гэж тооцно.

2. ШУТЗ-ийн хурлын тогтоолыг үндэслэн эрүүл мэндийн сайдын тушаалаар шинэ аргын зохиогч (чдод) гэрчилгээ олгоно.

Тав. Шинэ аргыг бүртгэх, мэдээлэх

1. Шинэ аргыг ЭМЯ-ны Шинжлэх, технологийн асуудал хариуцсан нэгж бүртгэнэ.
2. Шинэ аргын мэдээний сан үүсгэж баяжуулалт хийж байна.
3. Шинэ аргын мэдээний санг ЭМЯ-ны веб хуудсанд байрлуулна.

Зургаа. Шинэ аргын зохиогчийг урамшуулах

- 6.1. Шинэ арга зохиогчид аргын шинэлэг байдал, ач холбогдлыг харгалзан нэг удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 хүртэл дахин нэмэгдүүлсэн хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.
- 6.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн урамшууллын мөнгийг зохиогчийн харьяа байгууллагаас гаргана.
- 6.3. Шинэ аргыг зохиогчийн бүтээлд тооцно.

Шинэ арга нь зохиогчийг байгууллага, салбарын шагнал, төрийн одон медалиар шагнах үндэслэл байж болохоос гадна Монгол Улсын төрийн шагналд зохих журмын дагуу дэвшүүлж болно.

Долоо. Шинэ аргыг нэвтрүүлэх, ашиглах

Оношлогоо, эмчилгээ, мэс заслын шинэ аргыг зохиогч өөрийн санаачлагаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлж, үр дүнг тооцож ажиллана.

Шинэ аргыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өргөн хүрээнд нэвтрүүлэх шаардлагатай бол Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохицуулна